



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
бэлгэдлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн бэлгэдлийн тодорхойлолт, эх загварыг хавсралт ёсоор баталсугай.

2.Дүүргийн бэлгэдлийг батлагдсан тодорхойлолт, загварын дагуу бүтээж, нийтэд сурталчлах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын  
07-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
бэлгэдлийн тодорхойлолт, эх загвар



1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, хороод, харьяа байгууллагууд нь энэхүү баталсан загварын дагуу бүтээгдсэн бэлгэдлийг хэрэглэнэ.

2. Чингэлтэй хайрхан уулыг эрт үеэс эрдэм номын бэлгэ тэмдэг болгон хүндэтгэж ирсэн уламжлалыг харгалзан түүнийг хүслийг хангагч Чандмань эрдэнээр төлөөлүүлэн дүрсэлнэ.

3. Чандмань эрдэнийг улаан, ногоон, хөх өнгийг тодоос шингэрээж, гурваар дагнах бөгөөд улаан өнгийг дээд талд нь голлуулж, зүүн талд нь ногоон, баруун талд нь хөх өнгийг байрлуулна.

4. Бэлгэдлийн оройд үеийн үед нар мэт мандаж, сар мэт гийгүүлж, гал мэт дүрэлзэн бадарч байхыг бэлгэдэн нар, сар, галын дүрсийг зална. Нар, сарыг шар өнгөөр, галыг улаан өнгөөр илэрхийлнэ.

5. Галыг төрийн соёмбо дээрх гал адилаар дүрсэлнэ.

6. Бэлгэдлийн суурьт эх дэлхий, газар нутгийнхаа ариун дагшин байдлыг чандлан хамгаалахыг бэлгэдэж цагаан өнгийн бадам цэцгийн дэлбээг голлуулан байрлуулна.

7. Бадам цэцгийн толионд нь "Чингэлтэй дүүрэг" гэсэн бичвэрийг шар суурин дээр хөх өнгөөр голлуулан бичнэ.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
бэлгэдлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн бэлгэдлийн тодорхойлолт, эх загварыг хавсралт ёсоор баталсугай.

2.Дүүргийн бэлгэдлийг батлагдсан тодорхойлолт, загварын дагуу бүтээж, нийтэд сурталчлах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

1150103053

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын  
07-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
бэлгэдлийн тодорхойлолт, эх загвар



1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, хороод, харьяа байгууллагууд нь энэхүү баталсан загварын дагуу бүтээгдсэн бэлгэдлийг хэрэглэнэ.

2. Чингэлтэй хайрхан уулыг эрт үеэс эрдэм номын бэлгэ тэмдэг болгон хүндэтгэж ирсэн уламжлалыг харгалзан түүнийг хүслийг хангагч Чандмань эрдэнээр төлөөлүүлэн дүрсэлнэ.

3. Чандмань эрдэнийг улаан, ногоон, хөх өнгийг тодоос шингэрээж, гурваар дагнах бөгөөд улаан өнгийг дээд талд нь голлуулж, зүүн талд нь ногоон, баруун талд нь хөх өнгийг байрлуулна.

4. Бэлгэдлийн оройд үеийн үед нар мэт мандаж, сар мэт гийгүүлж, гал мэт дүрэлзэн бадарч байхыг бэлгэдэн нар, сар, галын дүрсийг зална. Нар, сарыг шар өнгөөр, галыг улаан өнгөөр илэрхийлнэ.

5. Галыг төрийн соёмбо дээрх гал адилаар дүрсэлнэ.

6. Бэлгэдлийн суурьт эх дэлхий, газар нутгийнхаа ариун дагшин байдлыг чандлан хамгаалахыг бэлгэдэж цагаан өнгийн бадам цэцгийн дэлбээг голлуулан байрлуулна.

7. Бадам цэцгийн толионд нь “Чингэлтэй дүүрэг” гэсэн бичвэрийг шар суурин дээр хөх өнгөөр голлуулан бичнэ.